



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/524

Арвайхээр сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөл бөмбөгийн спортыг хөгжүүлэх зорилгоор “Арвайхээр футзалын лиг” аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 7,800,000 (долоон сая найман зуу мянга) төгрөгийг хавсралтаар батлан зарцуулсугай.

2.Дээрх 7,800,000 (долоон сая найман зуу мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 1043

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 30-ны өдрийн 1130/23 дугаар
захирамжийн хавсралт



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ
“АРВАЙХЭЭР ФУТЗАЛЫН ЛИГ”-ИЙН ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ**

Д/д	Нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт
1	Багийн шагнал 1-р байр	1	2,000,000	2,000,000
2	Багийн шагнал 2-р байр	1	1,500,000	1,500,000
3	Багийн шагнал 3-р байр	1	1,000,000	1,000,000
4	1-р шүүгч	1	1,000,000	1,000,000
5	2-р шүүгч	2	500,000	1,000,000
6	Цагчин шүүгч	1	400,000	400,000
7	Онооны шүүгч	1	400,000	400,000
8	Шилдэг тоглогчдын шагнал	3	100,000	300,000
9	Туслах шүүгч	2	100,000	200,000
Нийт				7,800,000

-оОо-